Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1737714.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 36947.9 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,933.04	18,397.63	9,464.59
Мөнгөн хөрөнгө	0	0	0.00
Авлага	715.362	339.101	-376.26
Урьдчилгаа	0	0	0.00
Бараа материал	8,217.68	18,058.53	9,840.85
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,765,729.63	1,719,317.06	-46,412.57
Үндсэн хөрөнгө	2,455,475.84	2,487,080.62	31,604.78
Хуримтлагдсан элэгдэл	-115,619.76	-120,142.47	-4,522.71
Нийт хөрөнгө	1,774,662.67	1,737,714.69	-36,947.98
Өр төлбөр	508.515	100.762	-407.75
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,774,154.16	1,737,613.93	-36,540.23
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,774,662.67	1,737,714.69	-36,947.98

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд авлага дансны үлдэгдэл 715.3 мянган төгрөг байсан ба харин тайлант онд авлагын данс 339.1 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ОНХС-аас өвсний үнэ шилжүүлэхдээ давхардуулан гүйлгээ хийсэнтэй холбоотой 285.9 мянга, Үйлдвэрчний эвлэлийн татвар 53.1 мянган төгрөг илүү шилжүүлсэн холбоотой үүссэн байна.

Өглөг дансны эхний үлдэгдэл 508.5 мянган төгрөг байсан ба тайлант онд 100.7 мянган төгрөг болж буурсан байна. Энэ нь 2019 оны ХАОАТ-ын өглөгийг барагдаагүй байсантай холбоотой үүссэн өглөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18058.5 мянган төгрөг болж 9840.8 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар 14700.0 мянган төгрөгийн тэжээл, 10000.0 мянган төгрөгийн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн өвс авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2487080.6 мянган төгрөг болж 31604.7 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-н хөрөнгөөр хийгдсэн ажлыг тус сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.12.15-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 69920.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэсэн, 2020.02.17-ны өдрийн А/101 тоот аймгийн Засаг даргын захирамжаар “Дутагдсан болон маргаантай хөрөнгийг талаар авах арга хэмжээний тухай” захирамжийн хэрэгжилтээс харахад 21235.3 мянган төгрөгийн ахуй үйлчилгээний барилгыг 2013.12.24-ны өдрийн 167 тоот аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор акталсан боловч данс бүртгэлээс хасаагүй байсныг тайлант онд данснаас хасалт хийсэн байна. Харин маргаантай байсан дизель моторыг 2020.04.15-ны өдрийн аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020.04.15-ны өдрийн А/98 тоот албан бичигт, Аймгийн ИТХ-ын 2010 оны 72 дугаар тогтоолоор дагуу 2010 онд худалдаж Орон нутгийн өмчийн газар 4500.0 мянган төгрөг нь шилжүүлсэн, үлдэгдэл 500.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын дансанд тушаасныг Орон нутгийн өмчийн газрын дансанд шилжүүлсэн тул өмчийг данснаас хасаж зарлагыг орон нутгийн өмчийн газарт

ирүүлэхийг мэдэгдье гэсэн албан тоотын дагуу машин тоног төхөөрөмжийн бүртгэлд байсан 36542.3 мянган төгрөгийн өртөг бүхий дизель моторыг данснаас хассан мөн 2020.11.06-ны өдрийн 108 тоот аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2250.0 мянган төгрөгийн программ хангамжийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1-5-р багуудын мэдээллийн төвүүдийг хашаажуулах 14350.0 мянга, Наадмын талбайн засварын ажил 9850.0 мянга, Өргөөтийн харзны эхийг хамгаалах 7920.0 мянга, Хайрхан багт Юнителийн шилжээ тавих 29800.0 мянга, Үнэгт багт хадлангийн тайлбай хаших 8000.0 мянга нийт 69920.0 мянган төгрөгийг хөрөнгийг хүлээн авч дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1737613.9 мянган төгрөг болж 36540.23 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 36540.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 563746.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 136662.9 мянган төгрөгөөр буюу 24.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ орон нутгийн санхүүжилт 129964.3 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. Төсөвт байгууллагын дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 9386.7 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 129964.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 582384.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 135149.2 мянган төгрөгөөр буюу 23.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамжийн материалын зардал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, бараа, үйлчилгээний бусад зардал нэмэгдэж тайлант онд 17902.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдсаны гарз бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 402955.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 402955.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 79533.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 454828.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 454828.0 мянган төсөв батлагдаж 2020 оны 10-р сард тодотгол хийн 457952.3 мянган төгрөг болж 3124.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант оны 12-р сарын байдлаар 457952.3 мянган төгрөгийн санхүүжилтээр, 1000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 456952.3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 500.0 мянга нийт 457952.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 443415.5 мянган төгрөгийг зарцуулж 14536.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 443415.5 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 5399.1 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 956.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 182.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 1526.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 238.6 мянга, томилолт зочны зардлыг 3688.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 19.0 мянга, нормативд зардал 23.0 мянга, эд хогшил худалдан авах зардал 80.0 мянга, томилолт зочны зардал 2467.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 228.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2523.9 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 2657.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 7298.9 мянга, 81806 арга хэмжээ 2924.9 мянга, 80305 арга хэмжээ 2657.3 мянга, 81102 арга хэмжээ 91.1 мянга, 82212 арга хэмжээ 1564.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр арга хэмжээгээр/

мянган.төг

№	ЭЗЭ	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗЭРҮҮ	ХУВЬ
Хөтөлбөр-70106.ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага						
Нийт дүн			459,095.16	443,415.50	15,679.65	96.58
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал		302,485.16	294,043.32	8,441.83	97.21
1	210101	Үндсэн цалин	151,206.50	149,854.51	1,351.99	99.11
2	210102	Нэмэгдэл	39,953.40	37,831.79	2,121.61	94.69
3	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	18,433.10	18,232.22	200.88	98.91
4	210202	Тэтгэмжийн даатгал	1,923.20	1,834.17	89.04	95.37
5	210203	ҮОМШ-ний даатгал	1,538.60	1,427.99	110.61	92.81
6	210204	Ажилгүйдлийн даатгал	384.60	365.41	19.19	95.01
7	210205	Эрүүл мэндийн даатгал	3,846.40	3,765.23	81.17	97.89
8	210301	Гэрэл, цахилгаан	5,791.50	5,801.35	-9.85	100.17
9	210302	Түлш, халаалт	16,254.60	16,062.40	192.20	98.82
10	210401	Бичиг хэрэг	3,096.30	3,077.30	19.00	99.39
11	210402	Тээвэр, шатахуун	17,755.00	17,755.00	0.00	100.00
12	210403	Шуудан, холбоо, интернэт	831.70	831.70	0.00	100.00
13	210404	Ном, хэвлэл	2,000.00	2,000.00	0.00	100.00
14	210405	Хог хаягдал зайлуулах, хортон	360.00	360.00	0.00	100.00
15	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	600.00	600.00	0.00	100.00
16	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000.00	977.00	23.00	97.70
17	210601	Багаж, техник, хэрэгсэл	9,500.00	9,500.00	0.00	100.00
18	210602	Тавилга	8,000.00	8,000.00	0.00	100.00
19	210604	Урсгал засвар	2,534.90	2,454.90	80.00	96.84
20	210702	Дотоод албан томилолт	9,236.16	6,170.00	3,066.16	66.80
21	210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,285.00	1,285.00	0.00	100.00
22	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	1,390.20	1,390.20	0.00	100.00
23	210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	300.00	300.00	0.00	100.00
24	210804	Тээврийн хэрэгслийн татвар	500.00	500.00	0.00	100.00
25	210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,564.00	3,497.16	66.84	98.12
26	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200.00	170.00	1,030.00	14.17
80106	Баг, хорооны ҮАЗардал		75,895.80	72,970.89	2,924.91	96.15
1	210101	Үндсэн цалин	54,160.00	52,751.34	1,408.66	97.40
2	210102	Нэмэгдэл	4,492.80	3,975.93	516.87	88.50
3	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	5,762.00	5,350.29	411.71	92.85
4	210202	Тэтгэмжийн даатгал	606.50	569.73	36.78	93.94
5	210203	ҮОМШ-ний даатгал	485.20	443.16	42.05	91.33
6	210204	Ажилгүйдлийн даатгал	121.30	163.75	-42.45	135.00
7	210205	Эрүүл мэндийн даатгал	1,213.10	1,205.80	7.30	99.40
8	210301	Гэрэл, цахилгаан	350.40	350.40	0.00	100.00
9	210302	Түлш, халаалт	567.00	567.00	0.00	100.00
10	210401	Бичиг хэрэг	1,736.20	1,736.20	0.00	100.00
11	210402	Тээвэр, шатахуун	4,320.00	4,320.00	0.00	100.00
12	210403	Шуудан, холбоо, интернэт	550.30	550.30	0.00	100.00

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Хөтөлбөр-70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага						
13	210601	Багаж, техник, хэрэгсэл	300.00	300.00	0.00	100.00
15	210702	Дотоод албан томилолт	1,144.00	600.00	544.00	52.45
16	210804	Тээврийн хэрэгслийн татвар	27.00	27.00	0.00	100.00
17	210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	60.00	60.00	0.00	100.00
	80305	Ажил олгогчоос олгох тэтгэмж	56,474.90	53,817.57	2,657.33	95.29
1	213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэм	50,874.90	48,622.07	2,252.83	104.63
2	213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	5,600.00	5,195.50	404.50	92.78
	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	14,739.30	14,648.15	91.15	99.38
1	210901	Бараа үйлчилгээний бусад зарда	14,739.30	14,648.15	91.15	99.38
	82212	Хур хог хаягдал, орчны бохирдол	9,500.00	7,935.57	1,564.43	83.53
1	210801	Бусад нийтлэг АУТХураамж	7,597.20	7,435.57	161.63	97.87
2	210901	Бараа үйлчилгээний бусад зарда	1,902.80	500	1,402.80	26.28

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн өмчийг түрээслүүлсний орлого 9974.8 мянга, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 847.2 мянга, ХАОСТ-н материал тушаасан зардал 30.0 мянга, төрийн албан хаагчийн орон сууцны дэмжлэг 10000.0 мянга, цахим тендерийн хураамж 105.0 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2019 оны үйл ажиллагааны шагнал 2000.0 мянга, усны карт, өвс тэжээлийн үнэ тус тус 300.0 мянга, ГХУСЗ-ын үнэ 1040.0 мянган төгрөгийн Намжилаас, нийт 24717.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж холбогдох зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) мэдээллийг 1-3 саруудад, 1-р улиралд 107816.8 мянган төгрөгийн 4 мэдээлэл, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) мэдээллийг 1-3р сард, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) мэдээллийг 6-р сард, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) мэдээллийг 2-р сард, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) мэдээллийг 2,7-р саруудад 29896.5 мянган төгрөгийн 2 мэдээлэл, Бонд, зээл,

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт.3 Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	0	4	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	87	9	
	Нийт	27	151	133	16	2

ерийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) мэдээллийг 1-4-р саруудад нийт 29896.5 мянган

төгрөгийн 16 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 710.0 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	710.0	1	710.0			
Нийт дүн	1	710.0	1	710.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44217.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 174.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 41500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 2543.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ. /Хавсралт 1./

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 31196.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1725.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 29471.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчилд дахин давтахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг анхан шатны баримтаас түүвэрлэн шалгахад өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шинэ жилийн арга хэмжээний зардал, ажилтнуудын аяллаар явах арга хэмжээний зардалд зарцуулсан 710.0 мянган төгрөг зориулалт бусаар зарцуулагдсан тул төлбөрийн акт тогтоогдсоныг цалингийн зардлаас төлөөд суутган тооцоо хийгээгүй төсвийг зориулалт бусаар зарцуулсан байгаа тул төлбөрийн акт тогтоов.

Энэ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан цалингийн зардал” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Тус байгууллага халаалтын гэрээг Баянхонгор Эко дулаан ХХК-тай сард 2031.8 мянган төгрөгөөр 7.5 сараар буюу нийт 15238.5 мянган төгрөг төлөхөөр гэрээ хийсэн ба 1-4-р сард нийт 8127.2 мянган төгрөгийг төлөхөөс 9142.7 мянган төгрөгийг төлж байгууллагын нэхэмжлэхээс 1015.5 мянган төгрөгийг илүү төлөөд авлагаар бүртгээгүй зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 “14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд тус байгууллага нь тус сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй Баялаг орд ХХК-наас 2000.0 мянган, Гурван тамга ХХК-наас 2500.0 мянган, МБГ ХХК-наас 2000.0 мянган, нийт 6500.0 мянган төгрөгийн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансаар авсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дэх заалттай нийцэхгүй байна

1.2. Эрсдэл: Төрийн нэр барьж ашиг сонирхлын зөрчилтэй этгээдээс хандив авах

1.3. Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомж зөрчиж хандив тусламж авахгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд тус байгууллагын хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй бөгөөд дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл санхүүгийн тайланд 208971.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 7686.6 мянган төгрөг байгаа бөгөөд 201284.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.44. “Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Аймгийн ОНӨГ-т хандан өмнөх онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангийн мэдээллийн дагуу дахин үнэлгээ дансны бүртгэлийн зөрүүг залруулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс 16 төрлийн 29896.5 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

3.2 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан бусад хяналт шалгалтын дүнг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглан мөрдөн ажиллахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 “ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй байх

4.3. Өгсөн зөвлөмж: Өөрийн үйл ажиллагаа онцлогт тохируулан НБББББ-ыг боловсруулан холбогдох албан тушаалтнаар батлуулан мөрдөн ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

П. Амаржаргал

П.АМАРЖАРГАЛ 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.Цээням

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.Мөнхбат

Б.МӨНХБАТ 2021.02.25



Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/148/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Галуут сумын Засаг даргын Тамгын газар	Мянган төгрөг .

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шинэ жилийн арга хэмжээний зардал, ажилтнуудын аяллаар явах арга хэмжээний зардалд зарцуулсан 710.0 мянган төгрөг зориулалт бусаар зарцуулагдсан тул төлбөрийн акт тогтоогдсоныг цалингийн зардлаас төлөөд суутган тооцоо хийгээгүй төсвийг зориулалт бусаар зарцуулсан байгаа тул төлбөрийн акт тогтоов.	710.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Ш.Мөнхбаатар Ц.Ариунаа
2	Тус байгууллага нь Баянхонгор Эко дулаан ХХК-нд хоорондын тооцоо тухай бүр хийгээгүйгээс 1015.5 мянган төгрөгийг илүү төлөөд авлагаар бүртгээгүй зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.	1015.5	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	Ш.Мөнхбаатар Ц.Ариунаа
3	Тайлант хугацаанд тус байгууллага нь тус сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй Баялаг орд ХХК-наас 2000.0 мянган, Гурван тамга ХХК-наас 2500.0 мянган, МБГ ХХК-наас 2000.0 мянган, нийт 6500.0 мянган төгрөгийн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансаар авсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дэх заалттай нийцэхгүй байна	6500.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ш.Мөнхбаатар Ц.Ариунаа
4	Тайлант онд тус байгууллагын хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй бөгөөд дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл санхүүгийн тайланд 208971.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 7686.6 мянган төгрөг байгаа бөгөөд 201284.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ш.Мөнхбаатар Ц.Ариунаа
5	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс 16 төрлийн 29896.5 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ш.Мөнхбаатар Ц.Ариунаа
6	Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглан мөрдөн ажиллахгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Ш.Мөнхбаатар Ц.Ариунаа
ДҮН		8225.5			

оОо